

БАТЛАВ:

БОАЖЯ ХБОБНУГ-ЫН ДАРГА:

...../А.ЭНХБАТ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ  
ХҮЛЭЭСЭН:

“КЕВИН ИНВЕСТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

李伟 /ВАНГ ВЕЙ /



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН  
СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “КЕВИН ИНВЕСТ”  
ХХК-ИЙН ЖОНШ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: РР-000003/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 5167663/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн \_\_\_\_\_ /

Боловсруулсан:

“Кевин инвест” ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн Дэлгэржаргал /Ч.Дэлгэржаргал/

Улаанбаатар хот

2022 он

## Агуулга

1. Төслийн танилцуулга .....	2
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга .....	3
2.1 Нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	3
2.2 Байгаль орчин.....	3
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт .....	5
3.1 Агаарын тоосжилт .....	5
3.2 Гадаргын ус болон газрын доорх усны нөөц, хомсдол .....	5
3.3 Хөрсөн бүрхэвч.....	6
3.4 Ургамлан нөмрөг .....	6
3.5 Амьтны аймаг.....	6
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ .	7
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэжмээний төлөвлөгөөний биелэлт .....	8
6. Хог хаягдлын төлөвлөгөө .....	11
7. Ногоон байгууламжийн төлөвлөгөө .....	13
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	14
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	16
10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө .....	17
11. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	18
12. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв.....	19
14. Хавсралт материалууд	

## 1. Төслийн танилцуулга

“Кевин Инвест” ХХК-ийн хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн хүрээнд уг үйлдвэрийг эрдэс түүхий эдээр хангах, хүдэр баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан хэрэгжүүлэх зорилт тавигдаж байна.

Уг зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл хэмээх баримт бичгийг “Молор-Эрдэнэ Арвижих” ХХК боловсруулан Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. ТЭЗҮ-ийн дагуу баяжуулах үйлдвэр дээр бүтээн байгуулалтын ажил хийгдэж, 2008 оноос хүдэр баяжуулах үйлдвэр ажиллаж эхэлсэн.

Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголыг Эрдэс баялгийн сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаалын 7.3-д заасныг үндэслэн боловсруулав.

“Кевин Инвест” ХХК нь Монгол улсын 9019034023 бүртгэлийн дугаар бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ эзэмшдэг бөгөөд хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрлэл эрхлэх эрхийг 2007 оны 09 дүгээр сард авсан. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/121 тоот шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 10.8 га газрыг 5 жилийн хугацаатай олгосон. Уг зөвшөөрлийг 2017 онд Даланжаргалан сумын засаг даргын 2017 оны 02 сарын 01 өдрийн А/222 тоот шийдвэрээр 15 жилийн хугацаатай сунгасан.

Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь анх жилд 75 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтайгаар 2008 онд ашиглалтад орсон ба 2013 оноос үйлдвэрээ өргөтгөн жилд 150 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай ажиллаж байна.

“Талст дөл” ХХК нь 2021 оны 11 дүгээр сард тус үйлдвэрийг түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд бага агуулгатай олборлосон жоншийг худалдан авч баяжуулан 95%-с доошгүй агуулгатай жоншны баяжмал үйлдвэрлэж авто зам, төмөр замаар Үйлдвэр-Олон Овоо өртөө-БНХАУ-ын Эрээн хот гэсэн маршрутаар тээвэрлэнэ.

## 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

### 2.1 Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Даланжаргалан сум Ардын хувьсгалын ялалтын дараахан нутгийн захиргаадыг байгуулахад Хан Хэнтий аймгийн Оцол сансар уулын хошуунд харьяалагдаж байгаад 1924 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн V тогтоолоор “Даланжаргалан сум” нэртэйгээр Боржигон Цэцэн вангийн хошууны нутаг "Элдэв" хэмээх газарт байгуулагджээ. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдан 1957 онд одоогийн төвлөрч байгаа Цомог хэмээх газарт суурьшсан байна. Тус сум 404.5 мян.га газар нутагтай, нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км-т төвлөрдөг.

Даланжаргалан сум нь засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 нэгжтэй, 2700 хүн амтай, 821 өрхтэй, 126,7 мян.толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй ба сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар шинээр үүсэн хөгжиж байна. Сумын нутаг дэвсгэрээр Монгол орныг дамжин Ази Европ тивийг холбосон авто болон төмөр зам дайран өнгөрдөг төдийгүй, их хөлийн газар юм. Тус суманд ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, 300 гаруй сурагчидтай 9 жилийн болон бага сургууль, эрүүл мэндийн төв, 150 гаруй хүүхэдтэй “Номт ирээдүй” цэцэрлэг, соёлын төв, цагдаагийн хэсэг, Сүгмэл эм эргэлтийн сан, Зэвсэгт хүчний 281-р байгууламж зэрэг төрийн байгууллагууд, болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байнгын үйл ажиллагаа явуулж байна. Даланжаргалан сум усан болон утаат болор, чүнчигноров, гартаам, мана, өнгөт чулуу, төмрийн хүдэр, хайлуур жонш, нүүрс, хүрмэн чулуу, бал чулуу, шохойн чулуу, барилгын материалын түүхий эд зэрэг ашигт малтмал элбэгтэй.

### 2.2 Байгаль орчин

#### Уур амьсгал

Тус сум хүйтэн, хуурай урт өвөл, харьцангуй чийглэг богино зунтай эх газрын эрс тэс уур амьсгалтай, 7 дугаар сард дулааны дундаж хэм 25 градус, 12 дугаар сард 21 градус хүрч хүйтрэх ба хүйтний хугацаа 2 сар үргэлжилдэг, цаг уурын дорнодын мужид хамаардаг.

Урин дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал өсч хөгжих үе 120-130 хоног байх ба ургамал ургалтын үед 120-170 мм тунадас

унадаг. Хур тунадасны жилийн дундаж 165 мм бөгөөд үүний 10 мм нь 11-3-р сард, 155 мм нь 4 -10 дугаар саруудад унадаг бол жилийн туршид гол төлөв баруунаас хүчтэй салхилах бөгөөд салхины хүч нь хавартаа /4-5-р сар/ ширүүсдэг, шороон шуурга болохын өмнө нар хүрээлэн бүдгэрч тэнгэр улбар шар өнгөтэй болдог.

### **Амьтан ургамал**

Нутаг орны байгалийн онцлогоос шалтгаалан тус суманд 35 зүйл хөхтөн, 124 зүйлийн шувуу, 7 зүйл хэвлээр явагчид амьдардаг. Олон зүйлийн шавж, аалз, аалз хэлбэртэн, мөн бусад сээр нуруугүйтний зүйлүүд байдаг.

Ургамлын хувьд цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилно. Шарилжны төрлийн ургамлууд түгээмэл тохиолддог ба үүнээс хамгийн элбэг болох агиас шаргал шарилж, олон зүйлийн цэцэгт ургамлаар баялаг.

Тухайлбал: Цахилдаг, сараана, гоо юлт, 2 наст гол гэсэр, сэдэргэнэ, хонгорзул, сөөгөн эмгэн шилбэ, имт гичгэнэ, хатны шар цэцэг, баглуур, өргөст бутаргана, үлтэн могойн идээ, ногоон удвал, улаан бударгана зэрэг ургамлууд элбэг тохиолдох бөгөөд хуурайшилтай жилүүдэд өвслөг болон бутлаг ургамал нилээд тэсвэртэй ургадаг.

### 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн явцад агаарын бохирдол нэмэгдэх, хөрс элэгдэх, ургамлан бүрхэвч талхлагдах, дуу чимээний бохирдолтыг орчиндоо үүсгэх болон хог хаягдал ялгаруулах зэрэг гол сөрөг нөлөөлөл багагүй учрах болно. Эдгээрийн эрчим, үр нөлөө нь төсөл хэрэгжих явцад их боловч нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг сайтар гүйцэтгэн цаашид хяналт шинжилгээний хөтөлбөрийг зөвлөмжийн дагуу цаг тухайд хийж хэвшвэл гол сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм.

#### 3.1 Агаарын тоосжилт

Хүдэр ачих, буулгах түүхий эдийн овоолго болон хүдэр тээвэрлэлт хийх хүнд даацын машин зэргийн нөлөөллөөр их хэмжээний сул шороо дэгдэж агаарт байх нарийн ширхэгтэй тоосонцорын агууламж нэмэгдэх хандлагатай. Хүдэр бутлах, овоолго хийх, ачих зэрэг технологийн процессийн явцад тоос ихээр гарч агаарт дэгддэг. Хүдэр бутлах тээрэмдэх үйл ажиллагаа нь үйлдвэрийн байранд битүү орчинд явагдах тул агаарын чанарт онцгой нөлөө үзүүлэхгүй. Тиймээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон үйлдвэрийн талбай дахь хүдрийн овоолгоос хийсэх тоосны нөлөөллийг хяналтанд авч, эрх бүхий байгууллагаас стандартчилж тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давуулахгүй байх тал дээр анхаарч үйл ажиллагаагаа явуулна.

#### 3.2 Гадаргын ус болон газрын доорх усны нөөц, хомсдол

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах усны тооцооллоос авч үзэхэд 17 л/сек ус зарцуулж байна. Үйлдвэрт ашиглах өрөмдмөл худгийн 1-3-р түвшний бууралт 12-30 м усны ундарга нь 3-4.8 л/сек байна. Үүнээс үзэхэд жонш баяжуулах үйлдвэрт ашиглах гүний усны нөөц нь хязгаарлагдмал, нөхөгдөх хэмжээ бага зөвхөн улирлын чанартайгаар хур тунадас туйлын бага унадаг, түүнээс үүдэн газрын гүний усны хуримтлал маш удаан бий болдог, байнгын урсгалтай гол, горхи байхгүй зэрэг онцлогийг харгалзан уг төслийн үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэмжээ нь гүний усны нөөцөд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Тиймээс тус баяжуулах үйлдвэр нь ашиглах усны хэрэглээг багасгах, дахин ашиглах эргэлтийн системийг боловсронгуй болгох, төслийн үйл ажиллагаанаас гүний усны нөөц багасахаас урьдчилан сэргийлж байнгын хяналт шинжилгээний ажлыг явуулна.

### **3.3 Хөрсөн бүрхэвч**

Жонш баяжуулах үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан суманд 2009 оноос одоог хүртэл дулааны улиралд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирсэн. Тус үйлдвэрийн эдэлбэр газар нь 1.0 га бөгөөд үүний 65% нь барилгажсан талбай эзэлдэг. Жонш баяжуулах үйлдвэрийн онцлогоос шалтгаалан үйлдвэрийн талбайд хүнд даацын автомашины хөдөлгөөний эрчимшил их, хүдрийн овоолго бүхий талбай, уурын зуухны нүүрсний талбай зэргээс тоосжилт үүсдэг. Дээрх нөхцөл байдлын үүднээс үйлдвэрийн эдэлбэр талбайн өнгөн хөрс хууларч, суларсан, ургамлан бүрхэвч ихэнхи хэсгээр утсан ба үржил шимгүй хурдас бүхий шороон гадарга үүссэн. Мөн хүнд даацын машин техникийн хөдөлгөөний улмаас хөрс ургамлыг тоосоор дарах, гэмтээх, хөрсийг дагтаршуулах зэргээр талхагдалд оруулсан.

### **3.4 Ургамлан нөмрөг**

Үйлдвэрийн талбайн булан, хашаалсан талбайн захаар хөл газрын ургамал ургасан. Хөл газрын ургамал нь дасан зохицох, мэнд үлдэх чадвар сайтайн дээр шим тэжээлийн бодис ус чийгийг ашиглах чадвар өндөр зэрэг хэд хэдэн давуу талтай байдаг. Тиймээс тухайн бүс нутгийн ургамлын бүлгэмдэлд өөрчлөлт орох нөхцөл бүрдэж болзошгүй юм.

Автомашин техникүүдээс агаарт ялгарах хүхэрлэг хий, азотын болон нүүрсхүчлийн давхар исэл, мөн бусад химийн нэгдэл, нарийн ширхэгтэй тоосны дэгдэлт нь орчны хөрс, ургамлыг бохирдуулан улмаар биоценозод сөрөг нөлөө үүсгэх талтай байж болно.

### **3.5 Амьтны аймаг**

Жонш баяжуулах үйлдвэр нь Даланжаргалан сумын төвөөс 2 км-ийн зайтай, харьцангуй суурьшлын бүсэд байрладаг тул сээр нуруутан амьтдад шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсний мизо болон микро фауны амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

#### 4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” -ын дагуу боловсруулсан болно.



## 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ, төг	Нийт зардал төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	<i>Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр</i>							
- Үйлдвэрийн дотоод болон гадаад тээврийн замаас үүсэх тоосжилт - Халаалтын зуухнаас гарах хорт утаа - Хог хаягдлын цэгээс ууршилт үүсэх	Олон шинэ зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж түүнд хяналт тавьж байх	Үйлдвэрийн замууд	Тогтмол	тогтмол	Дотоод зардалд тусгасан		2023	MNS 4585 :2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, Агаарын тухай хууль, 2012, MNS 5013 :2001 MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
	Үйлдвэрийн замыг тэмдэгжүүлэх	Дотоод гадаад замууд	ш	2	20	40	2023	
	Тоосжилтыг бууруулах төлөвлөгөөт усалгааг	Дотоод гадаад замууд	м <sup>3</sup>	-	Дотоод зардлаар		2023	
	ТТ-ийн засвар үйлчилгээг хугацаанд нь хийж, оношилгоонд хамруулах	Техник хэрэгслүүд	Сар/жил	-	Дотоод зардлаар		2023	
2	<i>Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр</i>							
Үйл ажиллагааны үед	Усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах, ус хэмнэлтэт эко цорго суултуур нэвтрүүлэх	Ус ашиглах хэсэгт	ш	1	500	500	2023	Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Усны зохистой хэрэглээ	Танин мэдэхүйн мэдээ мэдээлэл хүргэх	ЕБС					2023.03.22	
Гадаргын усны бохирдол	Булаг шандны эхийг цэвэрлэх						2023	
3	Газрын гадарга, Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр							
Газрыг зөвшөөрөлгүй ухаж, сэндийчлэх, олон салаа зам үүсгэснээр хөрс эвдрэх	Газрыг зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх	Газар	Тогтоох боломжгүй	ҮАТ	ҮАЗ		2023	
	Олон салаа зам гаргахгүй байх нөхцөлийг хангах, тээврийн замыг тэмдэгжүүлэх	Газар	5	20	100.0		2023	
Ахуйн бохир дамжуулах шугам хоолойн гэмтлээс хөрс бохирдож болзошгүй	Ахуйн бохирын шугам хоолойд үзлэг, шалгалт хийх Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засаж, сэлбэх	Ахуйн бохир дамжуулах шугам, хоолой	ҮАЗ	ҮАЗ	ҮАЗ		2023	MNS 5924:2015. Нүхэн жорлон угаадасны нүх техникийн шаардлага
ТХ-ийн явах эд ангиуд гэмтэх, ШТМ асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй	ШТМ-ын асгаралтын шингээх материал, асгаралтын үед авах арга хэмжээ, асгаралтыг мэдээлэх, хязгаарлах, цэвэрлэх журам боловсруулж, мөрдөж ажиллах	Хөдөлгө өнд оролцож буй бүх тээврийн хэрэгсэл	Үйл ажиллагааны зардалд багтана	ҮАЗ	ҮАЗ		2023	Сонгож авсан шингээгч материалгыг хэрэглэх зааварчилгаа ШТМ асгаралтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах талаар баримталж буй уурхайн дотоод дүрэм, журам
Ахуйн болон бусад хог хаягдлыг зориулалтын	Хог хаягдлыг зориулалтын цэгт хаях, ангилан ялгах зориулалт бүхий хогийн	Хогийн цэг, хогийн	Хог хаягдлын зардалд тусгасан				2023	Хог хаягдлын тухай Монгол улсын хууль

бус газарт хаях, зориулалтын бус саванд хадгалах зэргээс хөрс бохирдож болзошгүй	савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах	савнууд хамаарна						
4	Ургамал нөмрөг, амьтны аймгийг хамгаалах чиглэлээр							
ТХ-ийн зорчих хөдөлгөөн болон үйлдвэрийн зам талбайгаас үүсэх тоосжилт орчны ургамлан нөмрөгийн ургах чадварт нөлөөлөх	Үйлдвэрийн дотоод болон гадаад зам, талбайг услаж тоосжилтыг дарж байх	Зам талбай	удаа	Төлөвлө гөөт усалгаа хийнэ	ҮАЗ	ҮАЗ	2023	Байгалийн ургамлын тухай хууль, (1995), 7.1.
Олон салаа зам үүсгэснээр ургамлан нөмрөг гэмтэх	Олон салаа зам үүсгэхгүй байх нөхцөлийг хангах, замыг тэмдэгжүүлэх	зам	Давхардсан				2023	Гамшгаас хамгаалах тухай хууль
Хог хаягдлыг зориулалтын бус саванд хадгалах, ил задгай хаяснаар ургамлан нөмрөг гэмтэх	Хог хаягдлыг ангилах ялгах, битүүмжлэл сайтай зориулалтын хогийн сав, хогийн цэгт хуримтлуулан, зайлуулах	Хогийн сав, хогийн цэг	давхардсан					
5	Амьтны аймагт нөлөөлөх нөлөөллийг бууруулах чиглэлээр							
Хог хаягдлыг зориулалтын бус саванд хадгалах, ил задгай хаях зэргээс мал амьтан	Хог хаягдлыг битүүмжлэл сайтай зориулалтын хогийн саванд ангилан ялгаж хадгалах	Хогийн сав, хогийн цэг	Давхардсан					Амьтны тухай хууль, 2012 6.1.7. үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;

хордох, гэмтэх аюултай				
ДҮН	340,000			

## 6. Хог хаягдлын төлөвлөгөө

Хаягдлын эх үүсвэр	Хаягдлын ангилал, төрөл	Хаягдлын хэмжээ	Менежментийн арга зам	Нэгжийн үнэ, мян.төг	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
sЗасварын газар	Хатуу : Ашиглах боломжгүй болсон эд анги Тосоор бохирлогдсон арчих материал	Урдчилан тооцоолох боломжгүй	Ашиглалт дууссан эд анги, хадгалан хаягдал төмрийг дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх, Тосоор бохирдсон арчих материал зэрэг АХХ-г тусгай зөвшөөрөлтэй байгууллагад нийлүүлэх	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023	Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг 23- р зүйл
	Шингэн: Ашигласан тос, Тостой холилдсон ус		Засвар үйлчилгээнээс гарсан хаягдал шингэнийг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгасан		2023	Хог хаягдлын тухай хууль, 2017.05.12
Химийн бодисын агуулах	Химийн бодисын сав, баглаа, боодол	-	Химийн бодисын үлдэгдэл, хаягдал, сав баглаа боодлыг гэрээний зайлуулна.		Үйл ажиллагааны зардалд тусгасан	2023	“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”
Ахуйн хатуу хог хаягдал		1 х/ө* 0.3кг өдөрт:	Хог хаягдлыг зориулалтын хогийн саванд ангилан ялгаж,		Гэрээний дүнгээр	2023	Хог хаягдлын тухай хууль

	32.1кг, сард: 963 кг, жилд: 7.7 тн	дахин ашиглах боломжтой хаягдлуудыг эрх бүхий байгууллагад нийлүүлнэ.			2017.05.12
Органик хаядал ашиглан компост бордоо хийж, ашиглах	Хүнсний ногооны хаягдал	Будаа болон улаан буудайн хальс, сүү цагаан идээний болон мал нядалгааны хаягдал, хүнсний ногооны ялзарсан үлдэгдэл, хоолны үлдэгдэл, хог ургамал, шарилж зэрэг органик гаралтай түүхий эдийг ашилан компост бордоо хийнэ	2,000,000	2023	
ДҮН:			2,000,000 төг		

## 7. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичгүүд
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ногоон байгууламжийн арчилгаа	Усалгаа, хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх	Ногоон байгууламж	л	10	25,000	250,000	Ургамал ургатын хугацаанд	
2	Эдэлбэр газрын ногоон байгууламжийн хэмжээний 10%-д ногоон байгууламж байгуулах	Ажилчдын суурин орчимд мод ургамал тарих		ш	50	5,000	250,000	Ногоон байгууламж байгуулах арга хэмжээг хэрэгжүүлж, арчилгаа тордолгоог жил бүр хийнэ	MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандартын дагуу нөхөн сэргээх.
3	Хүнсний ногоо тариалах-өмнөх жилүүдийн туршлагаар ажилчдын хүнсний хэрэглээний ногоо тарих	Органик хаядал ашигласан компост бордоогоор бордох		кг	Дахин боловсруулсан бүтээгдэхүүн				Компост бордоо техникийн шаардлага MNS 6705:2015
4	Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх	Үйлдвэрийн хашаанд		ш	500	5000	ҮАЗ		МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг
Арга хэмжээг хэрэгжүүлэх зардал: 500,000төг									

## 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж Тоо хэмжээ Нэгжийн үнэ, мян.төг Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<i>Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>					
Хүчтэй салхи шуурганаас аюул, осол гарах	Хүчтэй салхи, шуурга үед аян замд гарахгүй	Төслийн талбай болон ойр орчимд	ҮАҮ	2023	Гамшигаас хамгаалах тухай хууль, 2017.02.02
	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах	Үйлдвэрийн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023	
Гал түймрийн улмаас үйл ажиллагаа доголдох, зогсох	Ил задгай гал гаргахгүй байх, хэрэгцээт газруудад галын самбар, багаж хэрэгслийг байршуулах	Үйлдвэрийн байр сууц	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023	Галын аюулгүй байдлын тухай хууль, 3-р зүйл, MNS 5566:2005 MNS 0640:89 MNS 639:89
Аянга цахилгаанаас үүсэх аюул, осол	Үйлдвэрийн талбайд 1-2 ш аянга зайлуулагч байршуулах	Үйлдвэрийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023	Гамшигаас хамгаалах тухай хууль, 2017.02.02

Үер усны аюул тохиолдох	Үйлдвэрийн талбай, хаягдлын санг болзошгүй үер усны аюулаас хамгаалах, татсан суваг шуудууг цэвэрлэх, сэргээх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017.02.02
	Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед гадаа ажиллах ажилчдын гүйцэтгэж буй ажлыг түр зогсоох	Үйлдвэрийн удирдах албан тушаалтнууд	Үйл ажиллагааны зардалд тусгах	2023	
<i>Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>					
Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Үйлдвэрийн ажилчид	Үйл ажиллагааны зардалд тусгах	ХАБЭА-н төлөвлөгөө	MNS 4990:2000
	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх				MNS 4969:2000
	Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Үйлдвэрийн ажилчид	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	ХАБЭА-н төлөвлөгөө	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 15-р зүйл
Төслийн болзошгүй эрсдлийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын нэг жилийн нийт зардал:				ХАБЭА-н зардалаас	



## 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжигдэхүүний нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Ажлын хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Нийт зардал, төгрөг	Баримтлах хууль, журам, стандарт
<b>Агаарын чанар</b>							
Зөөврийн багажаар: Агаар бохирдуулагч хийнүүд: SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> Тоосонцор: PM <sub>10</sub> , PM <sub>2.5</sub>	мкг/м <sup>3</sup>	Үйлдвэрийн талбайд, Хаягдлын сангийн дэргэд Үйлдвэрийн хашааны гадна, салхины дээр 500м зайд	Жилд 2 удаа	3 цэг 2 удаа	ҮАЗ	ҮАЗ	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016
<b>Газрын доорх ус</b>							
Усны чанарын шинжилгээ	мг/л,	Ус хангамжийн цэг Ахуйн бохир	Улиралд 1 удаа	2 цэг 4 удаа			MNS 0900:2018 MNS 6561:2011
<b>Хөрсөн бүрхэвч</b>							
Хөрсний өнгөн хэсэг дэх хүнд металын агууламж (Pb, Cd, Hg, As, Cr, Sn, Sr, V, Cu, Ni, Co, Zn, Mo, Se, B, F, CN-)	мг/кг %	Мониторингийн цэгүүдэд: Үйлдвэрийн талбайд, Хаягдлын сангийн дэргэд Үйлдвэрийн хашааны гадна, салхины дээр 500м зайд	Жилд 2 удаа	3 цэг 2 удаа			MNS 5850 : 2019 зөвшөөрөгдөх дээд хэмжээ)
<b>Амьтан</b>							
Эргэлийн усан болон хаягдлын санд ирж буй шувууд, тэдгээрийн төрөл, тоо, давтамжийн хянах, бүртгэл хөтөлөх	тоо	Эргэлтийн усан сан болон хаягдлын санд	Хавар намар	2 удаа	Дотоод зардалд	Дотоод зардалд	Өмнө жилийн мониторингийн мэдээлэлтэй харьцуулан дүгнэлт хийх
<b>Нийт зардал</b>						2,796,000	

## 10. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

Хийгдэх ажил	Байршил	Хугацаа давтамж	Нийт зардал	Хариуцах эзэн	Холбогдох хууль, стандарт
Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх	Төслийн талбайд	2023	5,000,000	БОМ	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн (10.1 зүйл)
Хог хаягдлыг ангилан ялгах дахин ашиглах талаар ажиллагсад сургалт хийх	Үйлдвэрийн оффис	1 удаа	Дотоод зардал	БОМ	Хог хаягдлын тухай хуулийн (9.2.2-9.2.9 дэх хэсэг) хэрэгжилтийг хангана.
Үйлдвэрийн ажилчдыг жилд 1 удаа ЭМҮ-т хамруулах	Даланжаргалан сум	Жил бүр	Дотоод зардал	Эрүүл ахуйч	
ЕБС-ын сурагчдын дунд Байгаль хамгаалах талаар уралдаан зохион байгуулах /Эссэ, гар зураг.../			Давхардсан	Үйлдвэрийн дарга БОМ	Байгаль орчны үнэлгээний тухай хуулийн (14.1.2) хэрэгжилт хангагдана.
<b>НИЙТ ЗАРДАЛ:</b>			5,000,000		

## 11. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агууллага	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцах эзэн	Зохион байгуулах газар
Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын тамгийн газарт	Танилцуулга, илтгэл болон тайлан	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг байгаль танилцуулах	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал	БОМ	Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газар
Багийн иргэдэд	Орон нутгийн иргэдэд тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг танилцуулах	БОМТ-ний хэрэгжилтийн явцыг танилцуулах	Жилд 1 удаа		БОМ	Багийн төв
БОАЖЯ	Цахим	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам	2023 оны 11 дүгээр сарын 1-ний дотор системд оруулна		БОМ	БОАЖЯ Дорноговь аймгийн Байгаль орчны газар
Зардал:				100,000		

## 12. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

№	Зардлын хэлбэр	Төсөв
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	340,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	2,000,000
3	Ногоон байгууламж	500,000
4	Орчны хяналт шинжилгээний зардал	2,796,000
5	Удирдлага зохион байгуулалт	5,000,000
6	БОМТ хэлэлцүүлэх, тайлагнах зардал	100,000
7	Дүйцүүлэн хамгаалах	10,000,000
8	Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх	ҮАЗ
<b>ДҮН</b>		<b>20,736,000</b>

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information  
Журналын /Journal No: 9546212

Системийн огноо/System Date: 2022-12-26

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5041015151	ХАТАГТАЙ ЧУЛУУНБАТ ДЭЛГЭРЖАРГАЛ	10,368,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No MOFUMNUB	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number 100900013406	Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	10,368,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:  
НӨХӨН СЭРГЭЭЛТ БАТАЛГАА

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers



Овог, нэр/Fullname: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat  
Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer  
Баталгаажуулах код/Verification code:  
GICPX10RK7DQ9EUG

Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орлох чадамжтай тоон гарын үсгээр баталгаажсан болно.

*This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.*

Та <https://verify.khanbank.com/> вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

*You can verify this document by going to <https://verify.khanbank.com/> and entering the 16-digit verification code provided. You can also find more information about digital signature on this page.*

**Санамж:** Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зервел таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу